



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

Монголбанк

2025.08



- Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд
- Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд
- Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд

I.

**Мөнгөний болон
макро зохистой
бодлогын хүрээнд**

1. Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд:

1.1. Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд инфляцыг дунд хугацаанд 5 хувийн (+/-2 нэгж хувийн интервалтай) орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын одоогийн голч зорилт болох 6 хувийг 2027 оноос 5 хувь болгон бууруулна.

1.2. Макро-санхүүгийн харилцан нөлөөг харгалзан санхүүгийн системийн болзошгүй эрсдэлийг үнэлж, удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцсэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

1.4. Төв банкны бодлого, шийдвэрийг хүртээмжтэй хүргэх, хүлээлтийг удирдахад чиглэсэн олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 1.1

Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд инфляцыг дунд хугацаанд 5 хувийн (+/-2 нэгж хувийн интервалтай) орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын одоогийн голч зорилт болох 6 хувийг 2027 оноос 5 хувь болгон бууруулна.



Үндэслэл

Инфляцын хэлбэлзэл нь:

- Валютын ханш
- Гадаад шок
- Төсвийн зардал
- Инфляцын хүлээлт
- Нийлүүлэлтийн шок:
 - Цаг агаар, тээвэр, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ гэх мэт.

Стратеги:

- Эрэлтийн гаралтай инфляцын дарамтыг зөв таних.
- Нийлүүлэлтийн шинжтэй инфляцын нөлөө, түүний хоёр дахь үеийн нөлөөг таньж, шаардлагатай тохиолдолд хариу үйлдэл үзүүлэх.
- Инфляцын хүлээлтийг дунд хугацаанд тогтворжуулахад шаардлагатай бодлогын арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх.





- Дунд хугацаанд инфляцын зорилтыг хангахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ:
 - Түр зуурын эсвэл байнгын шинжтэй инфляцад нөлөөлж буй хүчин зүйлийг зөв таних
 - Инфляцад нөлөөлж буй хүчин зүйлийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, шокийн шалтгаан зэргийг харгалзаж, тооцоо судалгаанд үндэслэн ирээдүйд чиглэсэн шийдвэр гаргана.
- Инфляцыг өсгөх эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж мөнгөний бодлогын шийдвэр гаргахаас гадна ерөнхий макро эдийн засагт учирч болзошгүй хүндрэл, шокуудыг мөнгөний бодлогын шийдвэр гаргахад харгалзан үзнэ.

Зорилт 1.2

Макро-санхүүгийн харилцан нөлөөллийг харгалзан санхүүгийн системийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Үндэслэл

- Дэлхий дахинд үүсээд буй геополитикийн хурцадмал байдал, гео-эдийн засгийн хуваагдал, томоохон улс хоорондын худалдааны дайн зэрэг нь дэлхийн түүхий эдийн зах зээлд сөрөг шок, үнийн савлагааг бий болгож, Монгол улсын эдийн засагт бодитоор эрсдэл учруулж байна.
- Эдийн засагт гадаад сөрөг шок нэмэгдсэн энэ үед макро эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэрийг хангах, эдийн засгийн уналтаас сэргийлэх, тогтворжуулах нь бодлогын сорилт хэвээр байна.
- Монгол Улсын санхүүгийн системд /банкны бус санхүүгийн салбарын зээлийн хэт өсөлт, банк болон банк бус санхүүгийн байгууллагаас давхар зээлтэй иргэдээс үүдэлтэй/ тодорхой эмзэг байдлууд хадгалагдсаар байгаа нь эдийн засагт үүсээд буй сөрөг шокийн цар хүрээг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн системийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй юм.
- Макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлснээр мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн систем дэх эмзэг байдлыг бууруулж, системийн эрсдэл хуримтлагдан бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлнэ.





Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээний цогц загварыг сайжруулж, үр дүнг бодлогын шийдвэр гаргалтад ашиглана.
- Макро, санхүүгийн бодлогын нөлөөллийн шинжилгээг гүйцэтгэн, үр дүнг зах зээлд оролцогчдод мэдээлж, хүлээлтийг удирдах арга хэмжээнд ашиглаж эхэлнэ.
- Санхүүгийн системд үүсэж буй эрсдэлийн шинжилгээ, хяналтыг сайжруулан, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэгдсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.
- Макро зохистой бодлогын шийдвэрийг гаргахдаа мөнгөний болон макро зохистой бодлогын харилцан үйлчлэлийг харгалзан үзнэ.
- Макро, санхүүгийн бодлогуудын арга хэрэгслүүдийн үр нөлөө, харилцан хамаарлыг тодорхойлох шинжилгээний цогц арга зүйг хөгжүүлнэ.

Зорилт 1.3

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцсэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

Үндэслэл

Бодлого	Нөхцөл байдал	Шалтгаан
 Ханш уян хатан тогтох бодлого баримтлах	 ГАДААД ШОКОНД ӨРТӨМТГИЙ	Хуримталал бага- хөрөнгийн урсгал чөлөөтэй ЭЗ-ийн төрөлжилт бага-Уул уурхайн салбараас өндөр хамааралтай Хэрэглээ, үйлдвэрлэлд импортын орц өндөртэй
 Гадаад шок-ийг шингээх, ЭЗ-ийн нөөцийг үр ашигтай хуваарилах боломжийг бүрдүүлдэг.	 Гадаад валютын нөөцийг хадгалах	 Валютын ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын зах зээлд оролцох
Үр дагавар		Анхаарах асуудал

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Ханшийн хэлбэлзэл зах зээлд үүсэж улмаар санхүүгийн тогтвортой байдал алдагдахаас сэргийлэх үүднээс гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор Монголбанк тухай бүр захад оролцоно.
- Гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээт байдлыг тогтвортой хадгалах, нийт нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэр татах ажлыг зохион байгуулна.
- Валютын захын оролцогчдын хүлээж буй ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



Зорилт 1.4

Төв банкны бодлого, шийдвэрийг хүртээмжтэй хүргэх, хүлээлтийг удирдахад чиглэсэн олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Олон улсад төв банкны олон нийттэй харилцах харилцааг хүлээлтийг удирдах мөнгөний бодлогын хэрэгсэл болгон өргөн ашигладаг.
- **Олон нийттэй харилцах харилцаа:** Төв банкны үндсэн зорилт болон бодлогын зорилго, гаргасан шийдвэр, түүний үндэслэл болох эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөвийн талаарх мэдээллийг санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, бусад бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийт зэрэг оролцогч талуудад түгээх үйл ажиллагаа юм.
- **Хүлээгдэх үр дүн:**
 - *Бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх*
 - *Эдийн засаг, санхүүгийн зах зээлд тогтвортой байдлыг хангах*
 - *Нийгмийн сайн сайхан байдлыг дэмжих*
 - *Олон нийтийн итгэл, байгууллагын нэр хүнд, хууль ёсны байдлыг нэмэгдүүлэхэд мөн чухал үүрэг гүйцэтгэдэг*

Монголбанк олон нийттэй харилцах харилцаагаа хөгжүүлэхдээ дараах үндсэн зарчмуудыг баримтална:

- Төв банкны олон нийттэй харилцах харилцааг **олон улсын сайн туршлагуудыг** өөрийн орны онцлогт нийцүүлэн улам боловсронгуй болгоно.
- Олон нийтэд түгээх мэдээллийн агуулга, түгээх сувгуудыг хөгжүүлэхдээ **зах зээлд оролцогч талуудын санхүү эдийн засгийн суурь мэдлэг, зан төлөвийн онцлогт** нийцүүлнэ.
- Орчин үеийн **технологийн дэвшилтэт шийдлүүдийг** нэвтрүүлэх замаар мэдээлэл түгээх хурд, хамрах хүртээмжийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Мэдээллийн агуулга, чанарын сайжруулалтууд:

- Төв банкнаас олон нийтэд түгээх мэдээллийн чанар, агуулгыг тогтмол сайжруулах институц, процессийн шинэчлэлтүүдийг хийнэ.
- Эдийн засгийн шинжилгээ, төсөөллийн чанарт үнэлгээ хийж, сайжруулалтуудыг тогтмол хийнэ
- Мөнгөний бодлогын мэдэгдлийн формат, агуулгыг тогтмол сайжруулна
- Мөнгөний бодлогын тайлангийн бүтэц, агуулгыг тогтмол сайжруулна
- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийнэ
- Төв банкны дотоод мэдээллийн урсгалыг оновчтой болгох сайжруулалтуудыг нэвтрүүлнэ

Мэдээлэл түгээх сувгуудын шинэчлэлт:

- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохицуулах бодлогын баримт бичгүүдэд үнэлэлт шинэчлэлт хийнэ
- Төв банкнаас мэдээлэл түгээх сувгуудыг тасралтгүй хөгжүүлнэ
- Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлын зохион байгуулалтыг тогтмол сайжруулна
- Төв банкнаас нийтэлдэг статистик мэдээллүүдийг хуваарийн дагуу олон нийтэд түгээж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд нийгмийн цахим сүлжээг ашиглана
- Орон нутагт мэдээлэл түгээх үр дүнтэй сувгуудыг хөгжүүлнэ
- Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудтай тогтмол уулзалт, сургалтыг зохион байгуулалж, мэдээ мэдээллээр хангана
- Олон улсын байгууллагуудаас Төв банкны олон нийттэй харилцах харилцааны чиглэлд өгсөн зөвлөмжийн дагуу олон нийттэй харилцах үйл ажиллагааг боловсронгуй болгоно
- Төв банкны IAPOC индексийг сайжруулах олон нийттэй харилцах харилцааны өөрчлөлт, шинэчлэлтүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ



II.

**Банкны салбарын
тогтвортой
байдлын хүрээнд**

Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1. Банкны өөрийн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүнийг үр ашигтай байдлаар төрөлжүүлэн банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх замаар банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хяналт шалгалтын олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

2.2. Монгол Улсын эрсдэлийн үнэлгээ болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж стандартуудын өөрийн үнэлгээний үр дүнд суурилан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үндэсний бодлогыг шинэчлэх.

2.3. Банк, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх хүрээнд иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилт 2.1

Банкны өөрийн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүнийг үр ашигтай байдлаар төрөлжүүлэн банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх замаар банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хяналт шалгалтын олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Үндэслэл

Банкны өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын дотоод үнэлгээний аргачлал болон хяналт шалгалтын үнэлгээний аргачлал, шалгуур үзүүлэлтүүдийг олон улсын хяналт шалгалтын стандарттай нийцүүлж, өөрийн хөрөнгийг төрөлжүүлснээр банкуудын засаглал, эрсдэлийн удирдлага болон эрсдэл даах чадвар бэхжин банкны системийн тогтвортой байдлыг хангах, улмаар бодит эдийн засгийн өсөлтийг дэмжихэд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой.



Стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ

Стратеги:

- Банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа холбоог сайжруулж, олон улсын стандарттай нийцүүлэн тогтоох зорилгоор холбогдох эрх зүйн баримт бичгийг шинэчлэн найруулах, эдийн засаг, банкны салбарын нөхцөл байдалтай уялдуулан шат дараатайгаар нэвтрүүлэх зарчмыг баримтална.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:


- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах.
- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг банкнуудад танилцуулан хэлэлцүүлж, санал авах, хэрэгжилтийн хугацааг тодорхойлох.
- Базел стандартын Бүлэг 2-ын шаардлага болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (ILAAP)-г банкнууд дотооддоо үнэлэх, Монголбанкнаас хяналт шалгалтын үнэлгээг (SREP) гүйцэтгэхтэй холбоотой журмуудыг батлуулах.

Зорилт 2.2

Монгол Улсын эрсдэлийн үнэлгээ болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж стандартуудын өөрийн үнэлгээний үр дүнд суурилан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үндэсний бодлогыг шинэчлэх.



Хэрэгжүүлэх арга хэмжээ



Зорилт 2.3

Банк, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх хүрээнд иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

2025 оны байдлаар 71 улс иргэдийнхээ санхүүгийн боловсролыг дээшлүүлэх бодлогын баримт бичгийг батлан мөн 120 гаруй улс иргэдийнхээ санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байна. Монгол Улсын хувьд ч хөгжлийн түвшнээ даган иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэгцээ, ирээдүйн төлөвлөлт хийх чадвартай иргэн төлөвшүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлнэ.
- Иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Зорилтот бүлэг бүрийн онцлогт тохирсон сургалт, мэдээллийн арга хэлбэрийг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлнэ.
- Сургалт, мэдээлэл түгээх үйл ажиллагаанд технологийн дэвшилтэт шийдлийг нэвтрүүлж, ашиглана.



III.

**Санхүүгийн захын дэд
бүтэц, түүний
институцийг бэхжүүлэх
хүрээнд**

Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Цахим шилжилтийн хүрээнд үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, Stable Coin-ийг төлбөрийн хэрэгсэл болгох боломжийг судлаж, олон улсын зарчмын дагуу төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2. Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн хөгжлийн түгээмэл хандлага, олон улсын сайн туршлагад тулгуурлан холбогдох хуульд хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, үнэлгээний үр дүнд тулгуурлан шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах, чанаргүй зээлийг бууруулах хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.3 Бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд банкны зээл олголтын нөхцөл, шаардлагад үнэлгээ хийж, зээлдэгчийн хэрэгцээ, салбарын онцлогт нийцсэн зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны бодлогын арга хэмжээг боловсруулна.

Зорилт 3.1

Цахим шилжилтийн хүрээнд үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, Stable Coin-ийг төлбөрийн хэрэгсэл болгох боломжийг судлаж, олон улсын зарчмын дагуу төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

- Монголбанк нь Төв банкны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу төлбөрийн системийн үйл ажиллагаанд хяналт, зохицуулалтын чиг үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд зах зээлд шинээр нэвтэрч буй төлбөрийн үйлчилгээ, төлбөрийн хэрэгсэл, санхүүгийн зах зээлийн дэд бүтцэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.
- Түүнчлэн, олон улсын банк, санхүүгийн системд Төв банкуудын зүгээс цахимжсан төлбөрийн хэрэгсэл буюу цахим мөнгөний нэг хэлбэр болох Stable Coin-ийг гаргах талаар манай улсын эдийн засагт үзүүлэх өгөөж, хэрэглэгчдэд хүртээмжтэй байдал, олон улсын жишиг зэргийг судалж, төлбөрийн системийн оролцогчтой хамтарсан туршилтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна.



Стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ

- **Стратеги:** Үндэсний төлбөрийн системийн эрх зүй, зохицуулалтын орчны уялдаа холбоог сайжруулах, шинэ инновац, шилдэг технологид суурилсан төлбөр тооцооны хэрэгслийг дэмжиж ажиллах, төлбөрийн системд хяналт тавих замаар найдвартай, тасралтгүй байдлыг хангаснаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**
 - Төлбөрийн системийн оролцогчдын иж бүрэн хяналтыг хэрэгжүүлнэ,
 - Төлбөрийн системийн одоогийн дэд бүтцэд суурилсан банк хоорондын “нэхэмжлэлийн гүйлгээ”-г нэвтрүүлэхээр Монголбанк төлбөрийн системийн оролцогч нартай хамтран ажиллаж эхлээд байна.
 - Үндэсний төлбөрийн системийн хөгжлийг олон улсын жишигт нийцүүлэх үүднээс Stable Coin-ийг гаргахад үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох.



Зорилт 3.2

Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн хөгжлийн түгээмэл хандлага, олон улсын сайн туршлагад тулгуурлан холбогдох хуульд хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, үнэлгээний үр дүнд тулгуурлан шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах, чанаргүй зээлийг бууруулах ажлын хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

МУБТ СТТХ	ФАТФ шалгалт (2028–2029)-д бэлтгэн 2025–2026 онд хуулийн хэрэгжилтийг үнэлэх, шаардлагатай арга хэмжээг урьдчилан авч, бэлтгэл хангах.
ВЗТХ ТТҮМ ТГТХ	Үндэсний мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоо хийх зөвшөөрлийг салбарын хуулиар нарийвчлан зохицуулж, уг харилцаанд оролцогчдын эрх зүйн байдлыг сайжруулах, бодлогын түвшинд мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах талаар тодорхой шийдвэр гаргах зохицуулалтыг боловсронгуй болгох.
АУЭЗО	Актив удирдлагын мэргэшсэн институци байгуулах зохицуулалтыг бий болгох.

Стратеги




Зорилт 3.3

Бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд банкны зээл олголтын нөхцөл, шаардлагад үнэлгээ хийж, зээлдэгчийн хэрэгцээ, салбарын онцлогт нийцсэн зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны бодлогын арга хэмжээг боловсруулна.




тагатай

Зураг 15. Зээлийн хүү, барьцаа хөрөнгө, судлах үйл явц зэргээс шалтгаалан зээлийн хүсэлт гаргаагүй ААН-ийн эзлэх хувь



Зураг 16. Барьцаатай зээлийн эзлэх хувь



Зураг 17. Бизнесийн үйл ажиллагаанд санхүүжилтийн хүндрэлийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Дэлхийн банк, “Аж ахуйн нэгжийн түүвэр судалгаа”

Бизнесийн зээлийн хүртээмж:
 -Бусад орнуултай харьцуулахад барьцаа хөрөнгийн шаардлага өндөр, үнэлгээ бага.
 -Бусад улсуудтай харьцуулахад санхүүжилтийн хүндрэл хамгийн өндөр үзүүлэлттэй байна




Хувийн хэвшилд олгосон зээлийн нөхцөл



Эх сурвалж: Монголбанк

Хувийн хэвшлийн хүсэж буй зээлийн нөхцөл



Эх сурвалж: Монголбанк, "Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал түүвэр судалгаа"

- Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн нөхцөлийн зөрүү өндөр хадгалагдсаар байна.
- Банкнаас олгосон бизнесийн зээлийн хүү өсч, зээлийн дундаж хэмжээ багассан байна. Харин зээлийн олгосон хугацаа нэмэгдсэн.
- Харин эрэлт талаас харахад бизнес эрхлэгчид банкны олгож буй зээлийн хугацаанаас урт хугацаатай зээл авах хэрэгцээ, шаардлагатай байна.
- Зээлийн нөхцөл, шалгуурын зөрүүний шалтгааныг нарийвчлан судлах, тодорхойлох шаардлагатай.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Банкны зээл олголтын шалгуур, нөхцөлийг нэгдсэн үнэлгээ хийх мэдээллийг цуглуулах, харьцуулсан судалгааг хийж, ил тод мэдээлэл хүргэх.
- Зээлдэгчдийн **салбар, хэмжээ, бүс нутгийн онцлогт** тулгуурласан зээлийн эрэлт, хэрэгцээг судлах. Судалгааны үр дүнг банкуудын **зээлийн нөхцөл, бүтээгдэхүүн боловсруулах бодлогод тусгах эргэх холбоог бий болгох.**
- ЖДҮ болон дэвшилтэд, ногоон, цэвэр технологийн бизнесийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан, уян хатан эргэн төлөлт, улирлын орлоготой нийцсэн байдлаар банк зээлийн нөхцөлөө өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх бодлогын арга хэмжээний талаар судлах.
- Салбарын онцлогт нийцсэн, уян хатан хугацаатай, улирлын онцлогт тохирсон зээлийн бүтээгдэхүүний төрлийн талаар судлах.
- Барьцаа хөрөнгийн хүндрэлтэй ЖДҮ болон стартапуудын зээлд Зээлийн батлан даалтын сангийн оролцоог нэмэгдүүлэх.
- Зээлийн барьцаа хөрөнгийн төрөл, үнэлгээний аргачлалыг өргөжүүлж, бизнесийн онцлогт нийцсэн уян хатан нөхцөл бүхий бүтээгдэхүүн хөгжүүлэх санаачилгыг дэмжих;
- Банкууд болон финтекийн хамтын ажиллагааг дэмжиж, платформ суурьтай бизнесийн зээлийн шийдлийг үе шаттайгаар нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Бизнесийн орчныг сайжруулах чиглэлд олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах;





**Анхаарал тавьсанд
баярлалаа**